

МОНГОЛ-ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСАГ, ХУДАЛДААНЫ ХАРИЛЦААНД ӨМӨЗО-Ы ГҮЙЦЭТГЭЖ БУЙ ҮҮРЭГ

*Түмэнцэцэг**

Өнөөгийн дэлхий ертөнц, улс төрийн олон туйл, эдийн засгийн глобальчлал, мэдээллийн сүлжээний хөгжил, түүнчлэн орчин үеийн техник технологи, зам харилцаа, алсын холбоо зэрэг салбаруудын нисэх мэт хурдацтай хөгжлийг даган, бүхэлдээ аажмаар улам бүр холбогдож байна. ХХ зууны 90-ээд оноос Хятад, Монгол хоёр улсын улс төр, эдийн засаг, соёлын харилцаа хамтын ажиллагаа бүх талаар хурдацтай хөгжиж байна. ӨМӨЗО нь өвөрмөц газар нутаг, хил боомт, соёлын зэрэг давуу талаараа Хятад, Монгол хоёр улсын эдийн засаг, худалдаа, соёлын харилцаанд чухал ач холбогдол үзүүлдэг.

Нэг. ӨМӨЗО-ы газар нутаг, соёлын давуу тал

Хятад Монгол хоёр улс нь уул усаар холбогдсон, харилцан шүтэлцсэн хөрш улс билээ. Хоёр улс 4676,8 км урт газраар хиллэдэг. ӨМӨЗО нь эх нутгийнхаа хойд хэсэгт байрлаж, Монгол улс болон ОХУ-тай хил залгадаг. ӨМӨЗО, Монгол улсын хоорондын хилийн урт 3193 км бөгөөд Хятад, Монгол хоёр улсын нийт хилийн 70%-ийг эзэлдэг. Өвөр Монголын 15 хошуу Монгол улстай хил залгаа оршдог, хоорондоо нэг, хоёрдугаар зэрэглэлийн тус бүр 5 боомттой учраас Өвөр Монгол нь Монгол улсын эдийн засаг, худалдаа, соёлын харилцаанд газар нутаг болон боомтоороо давуу байр суурийг эзэлдэг. Өвөр Монгол нь Монгол улстай эн түрүүнд харилцадгаас Хятадын дотоод мужууд болон Монгол улстай харилцах гүүр, холбоос болдог.

Соёлын талаас нь авч үзвэл, ӨМӨЗО Монгол улс хоёр нь газар нутаг, хүн ардын дадал заншил, уламжлалт нүүдлийн соёл иргэншил зэрэг тал дээрээ адил тал ихтэй юм. Өвөр Монголын монголчууд, Монгол улсын монголчууд хил хязгаар заагтай ч нэг үндэстэн юм. Хэл яриа, соёл, үндэсний үзэл санаа, амьдралын зан заншил зэрэг адил талаараа Хятад, Монгол хоёр улсын эдийн засаг, соёлын харилцаанд сайн нөхцөл, чухал ач холбогдол үзүүлж, хоёр улсын хоорондын ажил хэрэг бүтэмжтэй, ард түмний хоорондын харилцаа хөгжиж байна.

* Түмэнцэцэг - Өвөр Монголын Их сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн хөрш орныг судлах хүрээлэнгийн захирал

Хоёр. Сүүлийн жилүүд дэх эдийн засаг, худалдаа, соёлын харилцаа

Ойрын хэдэн жилд, Хятад, Монгол хоёр орны дээд хэмжээний харилцан айлчлал байнгын болж, хоёр талын харилцаа улам хөгжиж, эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа, соёлын харилцаанд бат бэх үндэс суурь тавигдаж, цаашид хөгжих хандлагатай байна.

1. Эдийн засаг, худалдааны харилцаа

Хятад Монгол хоёр улсын эдийн засгийн харилцаа нь 1951 онд албан ёсоор худалдааны гэрээ байгуулснаар эхэлж 50 гаруй жил болж байна. XX зууны 90-ээд оноос Хятад Монголын эдийн засаг худалдааны харилцаа тогтворжиж, хөгжлийн шинэ үе шатанд орсон. Монгол улсын статистикийн мэдээгээр, 2000 онд Монгол Хятадын худалдааны нийт хэмжээ нь 400 сая ам.доллар, үүнээс импорт 125 сая ам.доллар болж, Монгол улсын импортын нийт хэмжээний 20,5%-ийг эзэлж байна. Экспортын хэмжээ 274 сая ам.доллар, Монгол улсын нийт экспортын 58,9%-ийг эзэлж байна. Өвөр Монгол нь Хятад Монгол хоёр улсын хоорондын худалдаанд харьцангуй чухал байр суурийг эзэлдэг. Бараа бүтээгдэхүүний худалдааг жишээ болгон авахад Хятад улсын статистикийн мэдээгээр сүүлийн хэдэн жилд Монгол улс - Өвөр Монголын худалдааны нийт хэмжээ нь Монгол Хятадын худалдааны нийт хэмжээний 49,2%-ийг эзэлж, Өвөр Монголоос импортлох хэмжээ нь Хятад улсын импортын хэмжээний 62%-ийг эзэлж байна. Гаалийн мэдээгээр, 1999 онд Өвөр Монгол, Монгол улсын хоорондын худалдааны нийт хэмжээ нь 85,42 сая ам.доллар болсноос импорт 58,6 сая ам.доллар, экспорт 27,35 сая ам.долларт хүрчээ. 2000 онд Өвөр Монголоос Монголд 84 сая 870 мян. ам.долларын бараа экспортлож, экспортын хэмжээ их хэмжээгээр өссөн байна.

XX зууны 90-ээд оноос эхлэн Хятад улсаас Монгол улсад оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь жилээс жилд өсөж байна. 1990 оноос хойш нийтдээ хятадын 512 аж ахуйн нэгж байгууллага Монгол улсад хөрөнгө оруулсан ба одоогийн байдлаар Монгол улсад гадаадаас хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн тоогоороо эхний байранд байна. 2000 оны сүүл гэхэд Хятадын талын хөрөнгийн нийт хэмжээ нь 76,9 сая ам.долларт хүрч, Монгол дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 30%-ийг эзэлж мөн л эхний байранд орж байна. Үүний дотор Өвөр Монголын аж ахуйн нэгж, хувь хүний оруулсан хөрөнгийн хэмжээ ихэнх хувийг эзлэж байна. Түүнчлэн Монгол улсын

ард иргэдийн аялах, худалдаа хийх, эмнэлэгт үзүүлэхээр эн түрүүнд очдог газар нь мөн л Өвөр Монгол юм.

2. Соёлын харилцаа

1990 оноос хойш Хятад Монголын соёлын байгууллагуудын харилцаа ихсэж байна. 1991 онд л гэхэд хоёр орны соёлын байгууллагуудын харилцан айлчлал 20 хүрчээ. Сүүлийн хэдэн жилд утга зохиол, урлаг, радио телевиз, кино, эрдэм шинжилгээний салбар дахь харилцаа хамтын ажиллагаа улам бүр нэмэгдэж, 2001 оны 6-р сард Хөх хот, Улаанбаатар хотууд найрамдалт хот болсоны 10 жилийн ойд зориулж Улаанбаатар хотод Хөх хотын соёлын өдрүүдийг зохион байгуулж, эдийн засаг худалдааны яриа хэлэлцээ, киноны өдрүүд, уран сайхны тоглолт зэрэг олон сайхан үйл ажиллагаа явуулсан байна. 1998 онд Өвөр Монголын радио телевизийн хороо, МРТХЭГ хамтын ажиллагааны гэрээ байгуулснаас хойш хоёр байгууллагын хоорондын өндөр хэмжээний харилцан айлчлал тасралтгүй хийгдэж байна. Энэ жилийн 4-р сард Өвөр Монголын радио телевизийн төлөөлөгчид Монгол улсад айлчлан хоёр талын хооронд нэмэлт гэрээ байгуулж, Өвөр Монголын телевизийн долоо хоногийг зохион байгуулж, улмаар Монгол улсад хязгаарлагдмал хариуцлагатай телевиз байгуулах, шинэ суваг нээх гэрээ хийсэн. Энэ жилийн 9-р сард Өвөр Монголын кино, телевиз, соёлын долоо хоногийг Улаанбаатар хотод зохион явуулсан нь 1998 онд хийгдсэн гэрээний дагуух хоёр орны радио телевизийнхний явуулж буй бас нэгэн томоохон арга хэмжээ бөгөөд Монголын ард түмэн Хятад улсын шинэчлэл нээлттэй бодлогын талаар илүү таньж мэдэх, хоёр орны соёл урлаг, радио телевизийн техникийн харилцаанд нилээд их ач холбогдлоо өгч, олны сайшаалыг хүртжээ.

1990 оноос хойш Хятад Монгол хоёр улсын шинжлэх ухаан, соёл, боловсролын харилцаа хамтын ажиллагаа ихээхэн хөгжиж байна. Өвөр Монгол болон Монгол улсын дээд сургууль, эрдэм шинжилгээ судалгааны салбар хоорондын харилцаа хамтын ажиллагаа тасралтгүй нэмэгдэж, Өвөр Монголын Их сургууль ба МУИС, Өвөр Монголын Багшийн Их сургууль ба Монгол улсын УБИС-иуд найрамдалт харилцаа тогтоож, хоёр талын харилцан айлчлал, эрдэм шинжилгээний солилцоо илүү идэвхитэй байна. Ялангуяа Монгол судлал, нүүдлийн соёл иргэншлийн талын эрдэм шинжилгээний харилцаа хамтын ажиллагаа илүү бэхжиж байна. 2000 оноос эхлэн Өвөр Монголын Их сургууль, Өвөр Монголын Багшийн Их сургууль, Өвөр Монголын Нийгмийн шинжлэх ухааны академийн хэсэг эрдэмтэд

НҮБ-ын ЮНЕСКО-гийн санаачилгаар Олон улсын нүүдлийн соёл иргэншлийн хүрээлэнгээс эрхлэн Хятад, Монгол, ОХУ-ын холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд хамтран зохион байгуулсан “Төв Азийн нүүдлийн соёл иргэншлийн хувьсал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээнийн хуралд оролцжээ. Энэ ажиллагаа нь Монгол улс, ОХУ, Хятад улсын Өвөр Монголд 2 жил болж байгаа бөгөөд энэ судалгааны ажил нь нүүдлийн соёл иргэншлийн түүх, өнөөгийн байдлын талаархи асуудлыг улам гүнзгийрүүлэн судлаж, олон улсын эрдэмтдэд харилцан суралцах, харилцаа холбоо тогтоох боломж олгосны зэрэгцээ Өвөр Монголын шинжилгээ судалгааны салбарт ашиг тустай нөлөө үзүүлжээ. Сүүлийн хэдэн жил Өвөр Монголын эдийн засаг нийгмийн хөгжлийг дагалдан дээд сургуулиудийн гадаад харилцааны нээлттэй орчин сайжирч Өвөр Монголд ирж суралцах Монгол иргэд нэмэгдэх хандлагатай байна.

Гурав. Оршин буй асуудлууд

Хэдийгээр ХХ зууны 90-ээд оноос хойш Хятад, Монгол хоёр улсын эдийн засаг худалдаа, соёлын харилцаа хамтын ажиллагаа тасралтгүй нэмэгдэн тодорхой үр дүнд хүрч байгаа боловч зарим нэг санаанд хүрэхгүй газар, хайхрахгүй байж болохгүй асуудал байна.

1. Өвөр Монгол нь улсдаа хөгжлөөр дутмаг, эдийн засгийн хөгжлийн түвшин хязгаарлагдмал нутаг учир Өвөр Монголын Монгол улсад оруулж буй хөрөнгө оруулалт нь харьцангуй сарниун байдаг. Хөрөнгө оруулагчдийн ихэнхи нь жижиг аж ахуйн нэгж, хувь хүн байдаг ба засгийн газрын хэмжээний байх нь ховор байдаг. Иймд хэдийгээр Монгол улсад хөрөнгө оруулж буй аж ахуйн нэгжийн тоо их боловч оруулж буй хөрөнгийн хэмжээ нь бага юм. Хятадын хөрөнгө оруулалттай эсхүл Хятад-Монголын хөрөнгө оруулалттай хамтарсан аж ахуйн нэгж дотор үйл ажиллагаа явуулж буй нь цөөхөн байна. 1999 онд Хятадын хөрөнгө оруулалттай 465 аж ахуйн нэгжээс үйл ажиллагаа явуулж байгаа нь 176 буюу 37,8%, үйл ажиллагаа нь зогссон 33 буюу 7,9%, үйл ажиллагаа эхлээгүй, үйлдвэрлэлээ зогсоосон аж ахуйн нэгж 256 буюу 55,9%-тай байна. Иймд энэ тал дээр засгийн газраас хяналт тавих, удирдан зохицуулах ажлыг хийж, Хятад, Монгол хоёр улсын эдийн засаг, худалдааны харилцааг хөгжүүлэх хэрэгтэй.

2. Бараа солилцооны асуудал дээр хуурамч барааг хил боомтоор оруулах, улсын хилээр гаргахыг эрс хориглох, үйлдвэр худалдаа, гаалийн байгууллагууд хуурамч бараатай тэмцэж, олон улсын

худалдааны ёс журмын дагуу тээвэрлэж, экспортыг нэмэгдүүлэх хэрэгтэй.

3. Соёл шинжлэх ухааны салбарт зохион байгуулалт, удирдлагын эмх замбараагүй байдлыг зогсоож, холбогдох хүний зохион байгуулалт, сахилга батыг сайжруулах, хоёр орны техник, соёл, боловсролын харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх хэрэгтэй.

4. Хятад, Монгол хоёр улс нь нийгмийн шилжилтийн үед явж байгаа ба хууль эрх зүйн асуудал нь бүрэн төгс бус, хууль тогтоомж гаргах, хэрэгжүүлэх ажил хангалттай бус, хоёр орны хоорондын үл ойлголцол, зөрчилдөөн харьцангуй их байгаа зэрэг нөхцөл байдлыг хоёр орон анхааралдаа авч, хууль дүрмийн сургалт, сурталчилгааг сайжруулж, хоорондын харилцаа холбоогоо бэхжүүлж, хуулийн дагуу ажиллах хэрэгтэй.

Дөрөв. Цаашдын хөгжлийн хандлага болон дэвшүүлж буй санал

Эдийн засгийн глобальчлал, мэдээллийн сүлжээний хөгжлийн хандлагыг задлан үзэхэд хөрш улсууд болох Хятад Монгол хоёр орны харилцаа хамтын ажиллагаа цаашид улам бүр бэхжих болно. Хятад улс Дэлхийн Худалдааны Байгууллагад орж, баруун бүс нутгийг хөгжүүлэх бодлого хэрэгжсэнээр Өвөр Монголын эдийн засаг нийгмийн хөгжил мөн хөгжих нэгэн шинэ боломжтой учирч байна. Өвөр Монголын эдийн засаг нийгэм хөгжсөнөөр гадаад эдийн засаг худалдааны харилцаа улам бүр өргөжин бэхжиж, Монгол улстай тогтоосон эдийн засаг худалдаа, шинжлэх ухаан техник, соёл урлагийн харилцаа улам бүр өргөжих болно. Хөрш улс болох Монгол улсын хувьд, Хятадын Өвөр Монголын хөгжил нь тус улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нь тус дөхөм болох нь эргэлзээгүй. Одоогийн байдлаар Монгол улсын засгийн газар экспортын чиглэлийн хөгжлийн стратегийг идэвхитэй явуулж байна. Нэг талаар олон улсын стандартад тохирсон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж хэрэглэж импортын татварыг багасгах, экспортын аж ахуйн нэгжийг дэмжин бараа бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, олон улсын зах зээл дээрх өрсөлдөх чадвараа бэхжүүлэх, экспортыг нэмэгдүүлж гадаад худалдааны орлого зарлагын бүтцийг сайжруулах, гадаад худалдааны өрийн*балансийг багасгах; нөгөө талаар хөрөнгө оруулах тохиромжтой орчинг бүрдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг их хэмжээгээр нь татах, улс дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдийг нэг адил дэмжиж, урамшуулах

зэрэг бодлого явуулах хэрэгтэй. Иймд бид дараахь хэдэн ажлыг гүйцэтгэх хэрэгтэй.

1. Өөртөө засах орны засгийн газар монгол улстай тогтоосон эдийн засаг худалдаа, соёлын харилцаа хамтын ажиллагааг чухалчилан анхаарч, холбогдох бодлого, арга хэмжээг авах, Өвөр Монголын газар нутаг, соёлын давуу талаа бүрэн ашиглаж, хоёр талын хамтын ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх.

2. Хятад улсын ДХБ-д элсэн орох боломжийг ашиглан өөртөө засах орны хөгжлийн алхмыг хурдасгах, Өвөр Монголын эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх хэрэгтэй. Өвөр Монголын газар нутаг, боомт, хүн ардын давуу талыг ашиглан дотоодын хөрөнгө болон техникийн бололцоог татсанаараа бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг хөдөлгөх.

3. ДХБ-д орох, баруун бүсийг хөгжүүлэх бодлогод бэлтгэн өөртөө засах орны олон улс судлалын ажлыг хүчтэй болгох, хууль тогтоомжийг сайжруулах, Өвөр Монголын хүний хүчин зүйлийг сайжруулах, хуулийн болон өрсөлдөөний талын мэдлэгийг нь дээшлүүлэх хэрэгтэй

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Монгол улсын Үндэсний Статистикийн Төв Газар <<Монгол улсын статистикийн эмхтгэл, 2000 он>> УБ 2001 он
2. ӨМӨЗО-ы Статистикийн Газар <<Өвөр Монголын Статистикийн эмхтгэл 2001 он>> Хятадын Статистикийн хэвлэлийн газар, 2001 он
3. Энхээ <<Зуун дамжсан Хятад Монголын эдийн засаг, худалдааны харилцаа: өнөөгийн байдал, хэтийн төлөв>> Өвөр Монголын Их сургуулийн мэдээ, 1999 он №
4. Монгол улсын ШУА-ийн ОУСХ, Өвөр Монголын Зүүн хойд Ази судлалын хүрээлэн <<Монгол Хятадын харилцаа: Нийгэм, эдийн засгийн асуудал (XX зууны 90-ээд он)>> УБ 2001 он
5. Жан Сюэие <<МУ-ын гадаад худалдааны харилцааны хөгжил>>, <<Зүүн хойд Азийн индэр>> 2001 он №

Хятад хэлнээс орчуулсан Хүмүүнлэгийн Ухааны Их
Сургуулийн IV курсийн оюутан **Ж.Хатанхүү**